

**БАТЛАВ**  
**МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН**  
**БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРАЛ**  
*Д.Уранжижүүлжилжилтүү* /Д.УРАНБИЛЭГ/  
**2019 оны 09 сарын 02**  
УУЗАЧЛУУСАН НОМ: 0077499

**МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВД  
ХҮҮХЭД СУРАЛЦУУЛАХ ГЭРЭЭ**

2019.09.16

№

Улаанбаатар хот

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1. Энэхүү гэрээг Монгол улсын Боловсролын багц хууль, Төвийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Сурагчдын дагаж мөрдөх дүрмийг үндэслэн нэг талаас Монголын хүүхдийн Урлан бүтээх төвийг /Цаашид “Төв” гэх/ төлөөлж Сургалтын менежер Бямба овогтой Батгэрэл нөгөө талаас Сургалтын чиглэлээр суралцах ..... овогтой ..... –ний эцэг /эх/, асран хамгаалагч ..... овогтой ..... нар харилцан тохиролцож байгуулав.
- 1.2. Талууд Төвд мөрдөгдөж буй дүрэм журам, энэхүү гэрээнд заасан эрх эдэлж, үүрэг биелүүлнэ.

**Хоёр. Төвийн эрх, үүрэг**

- 2.1. Сурагч бүрт чанартай, хүртээмжтэй мэдлэг, ур чадвар олгох, хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хүсэл сонирхол, онцлогт нь нийцсэн үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэн, бүхий л нөөц боломж, чадавхia дайчлан ажиллана.
- 2.2. Сургалтын орчин, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын стандарт, норм, нормативыг хангах, багшийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.3. Сургалт явуулахад зайлшгүй шаардагдах анги танхим, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үнэ төлбөргүй ашиглуулна.
- 2.4. Сурагч, эцэг эх, асран хамгаалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, хариуцлага тооцох эрхтэй.
- 2.5. Сурагч тасралтгүй амжилттай суралцаж төгссөн бол “Батламж” олгоно.

**Гурав. Суралцагчийн эрх, үүрэг**

- 3.1. Суралцах таатай нөхцөл, бололцоогоор хангуулах эрхтэй.
- 3.2. Төвийн дотоод журам, Сурагчдын дагаж мөрдөх дүрмийг хүндэтгэн сахих үүрэгтэй.
- 3.3. Сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших, амжилттай суралцахын төлөө өөрийн боломж, нөхцлөө бүрэн дайчлан ажиллах үүрэгтэй.
- 3.4. Багшийн өгсэн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх үүрэгтэй.
- 3.5. Төвөөс зохион байгуулах уралдаан тэмцээн, үзэсгэлэнд идэвхтэй оролцох үүрэгтэй.
- 3.6. Төвийн анги, танхимд тавигдсан бүтээлүүдийг гэмтээж, бохирдуулахгүй байх үүрэгтэй.

**Дөрөв. Эцэг, эхийн эрх, үүрэг**

- 4.1. “Өв соёлоо дээдэлдэг Бүтээлч Монгол хүүхэд” болон төлөвших, амжилттай сайн суралцаж, авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд гэр булийн хүрээний шаардлагатай нөхцөл боломжоор хангана.

- 4.1. “Өв соёлоо дээдэлдэг Бүтээлч Монгол хүүхэд” болон төлөвших, амжилттай сайн суралцаж, авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд гэр бүлийн хүрээний шаардлагатай нөхцөл боломжоор хангана.
- 4.2. Төв, багш нартай байнгын харилцаа холбоотой хамтран ажиллаж, хүүхдийнхээ мэдлэг, ур чадварын талаарх мэдээллийг цаг тухайд нь авах эрхтэй.
- 4.3. Хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар энэ гэрээнд заасны дагуу багштай хамтран ажиллана.
- 4.4. Хүүхдийн дэргэд багш нартай хүндэтгэлтэй харилцана.
- 4.5. Төвийн болон багш нарын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт гаргах, зөвлөх, ярилцах эрхтэй.
- 4.6. Өглөөний ээлж 09:00–10:40, өдрийн II ээлж 14.00–15.40, III ээлж 15.00–16.40 цагийн хооронд хичээллэх тул хичээл эхлэхээс 10-аас доошгүй минутын өмнө Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийг зам тээврийн осол, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд Анхан шатны буюу 1-5-р ангийн сургачийг удирдсан багшид гараас гарч хүлээлгэн өгч, хүлээн авна.
- 4.7. Төвийн анги танхимд тавигдсан бүтээлийг хүүхэд гэмтээсэн, бохирдуулсан тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч нь хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 4.8. Хүүхдэд халдварт өвчин туссан тохиолдолд бусад хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс эмчийн зааврыг сахиж энэ тухай багшид мэдэгдэх үүрэгтэй.

#### **Тав. Гэрээ цуцлах, хариуцлага тооцох**

- 5.1. Сурагч багшийн тавьсан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй, бусдыг хэл амаар доромжлох, нэр хоч өгөх, сэтгэл санааны болон бие махбодын хохирол учруулах, хулгай хийх зэрэг хүмүүжил, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд суралцах гэрээг цуцалж, холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.
- 5.2. Эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр сурагч цаашид хэвийн суралцах боломжгүй болсон тохиолдолд суралцах гэрээг цуцална.
- 5.3. Сурч, хөгжих үүргээ хангалтгүй биелүүлсэн сурагчид дараах хариуцлага тооцно. Үүнд:
  - 5.1.1. 2 өдөр буюу 4 цаг тасалсан бол сурагчид “Сануулга” өгнө.
  - 5.1.2. 4 өдөр буюу 8 цаг тасалсан бол эцэг эх, асран хамгаалагчид нь “Мэдэгдэх хуудас” хүргүүлнэ.
  - 5.1.3. 8 өдөр буюу 16 цаг тасалсан тохиолдолд суралцах гэрээг цуцлана.

#### **Зургаа. Бусад**

- 6.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хүчинтэйд тооцно.
- 6.2. Гэрээ цуцлах асуудлаар маргаан үүсвэл талууд холбогдох байгууллагад гомдол гаргах эрхтэй.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:**



Монголын Хүүхдийн  
Урлан Төвийн Сургалтын  
менежер

Б. Батчмын  
1 / Б. Батчмын /

Анги хариуцсан багш:

Б. Наран гарэл  
1 / Б. Наран гарэл /

Эцэг эх, асран хамгаалагч:

/Хавсралтаар/